

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндэсний аудитын газар

2018 оны 02 дугаар сар

Агуулга

Аудитын нэр, код

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт

Аудитын хамрах хүрээ

Үндсэн мэдээлэл

Эрсдэлийн үнэлгээ

Аудитын арга зүй

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудит хийх хугацаа

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

Хавсралт № 1 Эрсдэлийн үнэлгээ.....

Хавсралт № 2 Асуудлын шинжилгээ.....

Хавсралт № 3 Аудитын арга зүй.....

Хавсралт № 4 Аудит хийх багийн гишүүдийн ажлын хуваарь.....

Хавсралт № 5 Аудитын үр өгөөж.....

БАТЛАВ. МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

200
Д.ХҮРЭЛБААТАР

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016-2017 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн

2. Аудитын код

ГАГ-2018-06-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016-2017 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд дараах чиглэлээр аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Үүнд:

Иргэний нисэхийн ерөнхий газрын зарим үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Аудитын гол зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудаар асуудлын шинжилгээг боловсруулав. /Хавсралт № 3-д/ үзүүлэв.

- ✦ Мөнгөн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт үр нөлөөтэй байна уу?
- ✦ Агаарын тээврийг хөгжүүлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөтэй байна уу?
- ✦ Иргэний нисэхийн салбарын боловсон хүчний зарим үйл ажиллагаа үр нөлөөтэй байна уу?
- ✦ Иргэний нисэхийн 2016-2017 оны зарим санхүү, эдийн засгийн төлөвлөлт, гүйцэтгэл үр дүнтэй байна уу?

5. Аудитын хамрах хүрээ

Аудитыг Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016-2017 оны зарим үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн, тайлагналтай холбоотой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт, мэдээлэл холбогдох тооцоолол, судалгаа, байгууллага хоорондын гэрээ, хэлэлцээр, үйл ажиллагааны стратеги болон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, бусад баримт, мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэнэ.

Аудитад Зам, тээврийн хөгжлийн яамны холбогдох албад, Иргэний нисэхийн ерөнхий газрын 2 алба, 2 газар, 12 хэлтэс, 3 нэгж, 24 нисэх буудлын үйл ажиллагааг аудитын дэд зорилтод хамаарах асуудлын хүрээнд хамруулан шалгах бөгөөд аудитын дэд зорилт, асуудлын шинжилгээнд тусгагдаагүй бусад чиглэлээр болон бүрэн хэмжээгээр үйл ажиллагааг үнэлж, дүгнэх зорилго агуулаагүй болно.

Аудитын нэр хэдийгээр Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016-2017 оны үйл ажиллагааг тусгасан боловч шалгаж буй асуудлын онцлог байдлаас шалтгаалаад тодорхой тохиолдолд өмнөх онуудын болон 2018 оны үйл явдал, анхан шатны баримт, данс тооцоо холбогдох мэдээллийг шалгана.

6. Үндсэн мэдээлэл

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 38 дугаар тушаалаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлагдсан байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын эрхэм зорилго нь Иргэний нисэхийн болон нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт хийх, нислэгийн хөдөлгөөний удирдлага, холбоо, навигацийн техник тоног төхөөрөмж, мэдээлэл хангалт, нисэх буудал, газрын тусгай үйлчилгээ үзүүлэхэд оршжээ.

Дээрх зорилгыг хангахын тулд дараах чиг үүрэг, үйлчилгээг хэрэгжүүлж байна. Үүнд:

- ↓ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;
- ↓ Иргэний нисэхийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах;
- ↓ Агаарын хөлөгт нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэх;
- ↓ Агаарын хөлгийн нислэгт холбоо, агаарын навигацийн хангалт үйлчилгээ үзүүлэх;
- ↓ Нисэх буудлын газрын тусгай үйлчилгээ үзүүлэх;
- ↓ Иргэний нисэхийн салбарт нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангасан үйлчилгээ үзүүлэх;
- ↓ Мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалтыг зохион байгуулах;
- ↓ Төрийн захиргааны төв байгууллагаас шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх;
- ↓ Иргэний агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох;
- ↓ Иргэний нисэхэд дагаж мөрдөх стандарт, заавар, зөвлөмж, боловсруулах, хэрэгжилтийг хангах

Иргэний нисэхийн ерөнхий газар нь 2016 онд нийт 1,023,045 зорчигч тээвэрлэснээс олон улсын чиглэлд 790,459 зорчигч, орон нутгийн чиглэлд 232,586 зорчигч тээвэрлэсэн ба олон улсын чиглэлд тээвэрлэсэн зорчигчийн тоо өмнөх оноос 3.2 хувиар буюу 24,5 мянган зорчигчоор өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь 2016 онд Монгол улсын олон улсын агаарын тээврийн зах зээлд “Эйр Бусан” шинээр нэмэгдэж, Улаанбаатар-Бусан-Улаанбаатар чиглэлд, мөн “Хүннү Эйр” ХХК Улаанбаатар-Бугат-Улаанбаатар чиглэлд нислэг үйлдэж эхэлсэнтэй холбоотой байна.

2016 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 169,907.1 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 206,314.6 сая төгрөгийн орлого олж

36,407.5 сая төгрөгөөр буюу 21.3 хувиар орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлжээ.

2016 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд 45,714.2 сая төгрөгийн зардал батлагдсанаас, гүйцэтгэлээр 45,509.9 сая төгрөгийн зарцуулалттай байна.

ИНЕГ-ын 2016 оны хөрөнгө оруулалтын 119 төсөл арга хэмжээний эх үүсвэрт 2015 оны цэвэр ашгаас 4,900 сая, урсгал зардлаас 2,500 сая, улсын төсвөөс 13,500 сая, Хөгжлийн банкнаас 2,181 сая нийт 23,081 сая төгрөг батлагджээ.

2016 оны хөрөнгө оруулалтын тайлангаар нийт 14,949.8 сая төгрөгийн 106 төсөл арга хэмжээнд 2015 оны цэвэр ашгаас 3,708.9 сая төгрөг, урсгал зардлаас 1,697.8 сая, улсын төсвийн санхүүжилтээс 5,393.7 сая төгрөгийг тус тус санхүүжүүлжээ.

7. Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материалд үндэслэн аудитын эрсдэлийг "Дунд" гэж үнэлэв. / Хавсралт № 1 /

8. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд гүйцэтгэлийн аудитын удирдамж, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 3000-3100, гүйцэтгэлийн аудитын журам, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга судалгаа авах, мэдээ, тайланг судалж, нөхцөл байдлын шинжилгээ хийж, аудитын горимын дагуу аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна. / Хавсралт № 3 /

9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- ⚡ Монгол Улсын Үндсэн хууль
- ⚡ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- ⚡ Чикагогийн конвенци
- ⚡ Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- ⚡ Иргэний нисэхийн тухай хууль
- ⚡ Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль
- ⚡ Улсын нисэхийн тухай хууль
- ⚡ Төрийн албаны тухай хууль
- ⚡ Хөдөлмөрийн тухай хууль
- ⚡ Төсвийн тухай хууль
- ⚡ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ⚡ Улсын Их хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого"
- ⚡ Улсын Их хурлын 2015 оны 45 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"
- ⚡ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 57 дугаар тушаалаар баталсан "Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам"
- ⚡ Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 258 дугаар тогтоолоор баталсан "Иргэний нисэхийн ерөнхий газрын дүрэм"
- ⚡ Монгол Улсын Засгийн газрын 2015 оны "Дунд хугацааны стратеги батлах тухай"
- ⚡ Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 38 тушаалаар баталсан "үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"
- ⚡ Зам, тээврийн сайдын 2016 оны 94 дүгээр тушаалаар баталсан "Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр"
- ⚡ Холбогдох бусад хууль эрх зүйн актууд

10. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор М.Давааням, аудитын менежер З.Ариунзаяа нар удирдаж, ЧБА-ны ахлах аудитор И.Туяа, ГАГ-ын аудитор М.Наранжаргал, СУГ-ын шинжээч М.Доржханд, гэрээт ажилтан М.Пүрэвмаа нар гүйцэтгэнэ.

11. Аудитын хугацаа

Аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр хүртэл аудитын 5 үе шатны ажилбараар ажлын 51 хоногт багтаан гүйцэтгэхээр төлөвлөв.

12. Аудит хийх багийн гишүүдийн ажлын хуваарь

Багийн гишүүдийн аудитын 5 үе шатанд хийх ажлын хуваарийг боловсруулав.
/ Хавсралт № 4 /

13. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын зөвлөмж болон хавсралт хэсгүүдээс бүрдэнэ.

Аудитын тайлангийн төслийг аудит хийгдсэн байгууллагын удирдлагад танилцуулж, санал авахаас гадна тайлангийн эцсийн хувилбарыг Үндэсний аудитын газрын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж баталгаажуулан, холбогдох байгууллагад хүргүүлнэ.

14. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

- А. Боловсон хүчин: 4 хүн X 53 өдөр = 212 хүн/өдөр
- Б. Санхүүгийн нөөц: 6,000 мян/төг
- В. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер 4 ширхэг
- Г. Тээврийн зардал: 224,000 төгрөг

Аудитын төлөвлөгөөг

Хянаж зөвшөөрсөн:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ

С.ОЮУНБИЛЭГ

Боловсруулсан:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ДАВААНИЯМ

АУДИТЫН МЕНЕЖЕР

З.АРИУНЗАЯА

АХЛАХ АУДИТОР

И. ТУЯА



АУДИТОР



М.НАРАНЖАРГАЛ

М.ДОРЖХАНД

М.ПҮРЭВМАА

2018 оны 02 дугаар сарын 09-ны өдөр